

БАТЛАВ  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ЭРДЭНЭБИЛЭГ

2018 оны ..... сарын .....өдөр

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

2018 оны 08-р сарын 06 өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Дээд газрын тогтоол шийдвэр, захирамж, албан даалгаврын тус газрын чиг үүрэгт хамааралтай заалтуудын биелэлтэд хяналт шинжилгээ хийх ажлын хэсэг энэ удирдамжийг мөрдөнө.

	Хоёр. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Ахлагч:	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Ч.Шинэчимэг
Гишүүн:	Хууль эрх зүй, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ажилтан Э.Хоролдулам
Нарийн бичиг:	Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан Т.Итгэл

Гурав. Хугацаа

3.1 Ажлын хэсэг хяналт-шинжилгээг 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн 08 дугаар сарын 10-ны өдрийг дуустал хийнэ.

Дөрөв. Хамрах хүрээ

4.1 Ажлын хэсэг дараахь чиглэлээр хяналт-шинжилгээ хийнэ.

- хяналтын хуудасны асуултуудын хүрээнд хяналт-шинжилгээ хийх;
- холбогдох заалтуудын хэрэгжилтийн явц;
- холбогдох заалтыг хариуцсан албан хаагчийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;
- бүртгэл, тэмдэглэл, судалгааны хөтлөлт;
- шаардлагатай гэж үзсэн бусад ажил;

4.2 Ажлын хэсэг хяналт-шинжилгээ хийхтэй холбогдсон баримт бичгийг тухайн нэгж, ажилтнаас гаргуулан авах эрхтэй.

4.3 Ажлын хэсэг энэ удирдамжийн 4.1-д заасан ажлын хүрээнд хяналт-шинжилгээ хийж, гаргасан дүгнэлт, цаашид авах арга хэмжээний талаарх саналын хамт газрын даргад тайлагнана.

#### Тав. Бусад

5.1 Ажлын хэсэг хяналт-шинжилгээ хийхдээ холбогдох баримт бичгийг судлах, хариуцсан албан хаагчаас тодруулга авах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

5.2 Ажлын хэсгийн ахлагч нь гишүүдийн гүйцэтгэх үүргийг тодорхойлж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

5.3 Хяналтын хуудас нь энэхүү удирдамжийн салшгүй хэсэг байна.

5.4 Ажлын хэсгийн гишүүд хариуцсан чиглэл тус бүрээр шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдал, түүний шалтгаан нөхцөл, арилгах арга замын тухай дүгнэлт, танилцуулга бичнэ. Ажлын хэсгийн нарийн бичиг танилцуулгыг нэгтгэж, хяналт-шинжилгээний дүнгийн тухай илтгэх хуудсын төслийг боловсруулан ажлын хэсгийн хуралд хэлэлцүүлэн баталгаажуулна.

---o0o---

БОДЛОГЫН БОЛОН ЗАХИРАМЖЛАЛЫН БАРИМТ БИЧГИЙН ТУС ГАЗРЫН ЧИГ  
ҮҮРЭГТ ХАМААРАЛТАЙ ЗААЛТУУДЫН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ  
ХИЙСЭН АЖЛЫН ХЭСГИЙН

ИЛТГЭХ ХУУДАС

2018 оны 08 дугаар сарын 17

Улаанбаатар хот

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын даргын баталсан удирдамжийн дагуу бодлогын болон захирамжлалын баримт бичгийн тус газрын чиг үүрэгт хамааралтай заалтуудын биелэлтэд хяналт шинжилгээ хийх ажлын хэсэгт Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Ч.Шинэчимэг, хууль эрх зүй, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ажилтан Э.Хоролдулам, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан Т.Итгэл нар ажилласан ба 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрөөс 08 дугаар сарын 10-ны өдрүүдэд хяналт шинжилгээг хийлээ.

Ажлын хэсэг тус газрын даргын 2018 оны А/44 дүгээр тушаалаар батлагдсан “Бодлогын болон захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт, Нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх журам”-ыг удирдлага болгон ажиллалаа.

Нийт 1 бодлогын баримт бичгийн 13 заалт, 15 захирамжлалын баримт бичгийн 31 заалтыг хяналтанд авч, холбогдох заалтын хэрэгжилтийг хэлтэс, нэгж, хариуцсан албан тушаалтнаас гаргуулан, шаардлагатай зарим хэрэгжилтийг биеэр үзэж танилцсан.

Үр дүн:

Хяналт шинжилгээ хийх ажлын хэсэг дээд газрын тогтоол шийдвэр, захирамж, албан даалгаврын тус газрын чиг үүрэгт хамааралтай заалтуудын биелэлтийг үр дүнтэй /90-100/, бүрэн хэрэгжиж байгаа /90-100/ гэж үнэлсэн боловч, зарим бичгийн өөрийн үйл ажиллагаанд хамаарах заалттай хариуцсан албан тушаалтнууд танилцаагүй, мөн хамааралгүй заалтыг хяналтанд авах, зарим алба, нэгжийн төлөвлөлт, тайлагналт тоо, баримтад дутуу үндэслэгдсэн, үг үсэг, найруулгын алдаатай зэрэг дутагдал илэрсэнийг цаашид анхааран ажиллах тал дээр зөвлөгөө өгч ажиллав. Мөн УИХ, ЗГ-ын тогтоол шийдвэр, НЗД-ын захирамж, албан даалгаврыг цаг тухайд нь газрын даргын шуурхай зөвлөгөөн дээр тогтмол

танилцуулж, хамаарах заалтын хэрэгжилтийг хангаж, тайлан мэдээндээ тодорхой тусгаж байхыг үүрэг болгов.

Цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар:

- Албан хаагчдаас холбогдох заалтын хүрээнд хийсэн ажлын биелэлтийн мэдээ, үр дүнг хугацаанд нь тогтмол гаргуулж хэвших;
- Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр мэргэжлийн байгууллагаас сургалт авах;
- КРІ-ийг хэрэгжүүлэх, төлөвлөлт, тайлагналыг тодорхой тоо, баримт, судалгаанд үндэслэн гаргаж тайлагнах;

ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:  
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ  
ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ  
ХАРИУЦСАН АЖИЛТАН

Э.ХОРОЛДУЛАМ

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ